



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

### Аргачлал батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.22 дах заалтуудыг үндэслэн, Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бие даасан цахилгаан (дулаан) эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг тогтоох аргачлал”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан аргачлалын дагуу үнэ тарифыг тооцож, эрчим хүчний шинэ эх үүсвэрийн тарифыг хянахыг Үнэ тарифын бодлого, зохицуулалтын хэлтэс /Б.Болор-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.

ДАРГА

С.ОТГОНБАЯР

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Р.МЯГМАР

ЗОХИЦУУЛАГЧ

Г.ТАНТӨМӨР



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭРИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФ, БИЕ ДААСАН ЦАХИЛГААН (ДУЛААН) ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ГЭРЭЭНИЙ ГАРААНЫ ҮНИЙГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгааны тариф, бие даасан цахилгаан (дулаан) эрчим хүч үйлдвэрлэгчийн түлш ашиглан эрчим хүч үйлдвэрлэх шинэ эх үүсвэрийн эрчим хүч худалдах худалдан авах гэрээний гарааны үнэ тогтооход энэхүү аргачлалын зорилго оршино.

### Хоёр. Нэр томъёо

Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1. **Цахилгаан эрчим хүчний тэгшитгэсэн тариф (ЦТТ)** – Төсөл хэрэгжих болон ашиглалтын нийт хугацааны нэгж эрчим хүчний үнэ өртгийг өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэн тооцсон хэмжээ;

2.2. **Ашиглалтын үйл ажиллагааны зардал ( $AZ_{y.a}$ )** – Үндсэн хөрөнгийн элэгдэл, урт хугацаат зээлийн үндсэн төлбөр, хүүгийн зардал, өөрийн хөрөнгийн өгөөжийн дүнгээс бусад үйл ажиллагааны зардлын дүн;

2.3. **Үйлчилгээний биет хэмжээ ( $Y_{б.х}$ )** – Нэгдсэн сүлжээнд үйлдвэрлэн нийлүүлэгдэх цахилгаан (дулаан)-ы тоо хэмжээ;

2.4. **Хөрөнгө оруулалтын зардал ( $XO_{нийт}$ )** – Эрчим хүч үйлдвэрлэгчийн барьж байгуулахаар төлөвлөж буй эрчим хүчний шинэ эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын нийт зардал;

2.5. **Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувь ( $ӨX_{хувь}$ )** – Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн өөрийн хөрөнгөөс өгөөж тооцсон ашгийн хэмжээ;

2.6. **Үнэ цэнийн бууралтын хувь ( $YЦБ_{хувь}$ )** – Ирээдүйн мөнгөний урсгалд хорогдуулалт хийх замаар өнөөгийн үнэ цэнийг тооцох хувь хэмжээ;

### Гурав. Үнэ тарифыг тогтооход баримтлах зарчим

3.1. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн тариф, бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн гарааны үнэ тарифийг цахилгаан (дулаан) үйлдвэрлэх төсөл хэрэгжих хугацааны хөрөнгө оруулалтын зардал, ашиглалтын хугацааны



туршид тооцсон үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын өгөөж буюу ашигт ажиллагаа болон үйлдвэрлэлийн биет хэмжээнд үндэслэн тооцно.

3.2. Үнэ тариф тогтооход шаардагдах мэдээлэлд эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төсөлтэй холбоотой батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, мөнгөн урсгалын загварчлал болон үйлдвэрлэгчийн ирүүлсэн тарифын санал тооцооллыг ашиглана.

3.3. Эрчим хүч худалдах худалдан авах гэрээний гарааны үнэ тооцох тохиолдолд төсөл хэрэгжсэний дараах ашиглалтын хугацааны аливаа зардлын өсөлтийг тооцохгүй. Ашиглалтын хугацааны зардлын өсөлт нь эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлцлийн үнээр зохицуулагдана.

3.4. Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийн тариф тооцоход төсөл хэрэгжсэний дараах ашиглалтын хугацаанд ашиглалтын зардлын өсөлтийг тооцож болно.

3.5. Энэхүү аргачлалыг эрчим хүчний шинэ эх үүсвэрийн чадал болон энергийн тариф тогтооход ашиглаж болно.

3.6. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн үнэ тариф болон тариф мөрдөх хугацааг төслийн нийт зардал болон хөрөнгө оруулалтын өгөөжтэй уялдуулан тогтооно.

3.7. Сэргээгдэх эрчим хүчний тариф мөрдөх хугацаа нь энэхүү аргачлалаар тооцсон хөрөнгө оруулалтын өртөг нөхөх /үнэ цэнийн бууралт тооцсон/ хугацаанаас ихгүй байна.

### **Дөрөв. Бие даасан эрчим хүчний үйлдвэрлэгчийн цахилгаан (дулаан)-ы үнэ тарифын тооцоо**

4.1. Цахилгаан (дулаан)-ы эрчим хүчний үнэ тариф, гарааны үнийг тогтооход “цахилгаан (дулаан) эрчим хүчний тэгшитгэсэн тариф” (ЦТТ) тооцох аргачлалыг ашиглана. Үүнд цахилгаан (дулаан) эрчим хүчний үнэ тариф, гарааны үнийг тухайн эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын зардал болон эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах нийт хугацааны жил бүрийн бодит зардал, хөрөнгө оруулалтын өгөөж зэргийн өнөөгийн үнэ цэнэ рүү хорогдуулж тооцсон нийлбэрийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх цахилгаан (дулаан) эрчим хүчний биет хэмжээний өнөөгийн үнэ цэнэ рүү хорогдуулж тооцсон нийлбэрт харьцуулж тогтооно.

$$\text{ЦТТ} = \frac{XO_{\text{өх}} + \sum_{n=1}^N \left( \frac{Z_{\text{төлбөр}} - Э_{\text{ү.х}} * T_{\text{хувь}} + [AZ_{\text{ү.а}} + 3X] * [1 - T_{\text{хувь}}]}{(1 + Y_{\text{ЦБ}_{\text{хувь}}})^n} \right)}{\sum_{n=1}^N \left( \frac{Y_{\text{б.х}} * [1 - T_{\text{хувь}}]}{(1 + Y_{\text{ЦБ}_{\text{хувь}}})^n} \right)}$$

ЦТТ	- ЦЭХ-ний тэгшитгэсэн тариф;
$XO_{\text{өх}}$	- Өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын зардал;
$N$	- Үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах нийт хугацаа /жил/;
$n$	- Үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах тухайн жил;
$Э_{\text{ү.х}}$	- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал;
$T_{\text{хувь}}$	- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ;

ҮЦБ <sub>хувь</sub>	- Ирээдүйн үнэ цэнийг бууруулах хувь хэмжээ;
З <sub>төлбөр</sub>	- Төслийн санхүүжилтийн зээлийн эргэн төлөлтийн төлбөр;
АЗ <sub>ү.а</sub>	- Ашиглалтын зардал;
ЗХ	- Төслийн санхүүжилтийн зээлийн хүүгийн зардал;
Ү <sub>б.х</sub>	- Нэгдсэн сүлжээнд нийлүүлэх цахилгаан (дулаан)-ы биет хэмжээ;

4.2. Ирээдүйн үнэ цэнийг бууруулах хувь хэмжээ  $ҮЦБ_{хувь}$ -г капиталын жигнэсэн дундаж өртөг /КЖДӨ/-өөр тодорхойлно. Үүнд:

$$ҮЦБ_{хувь} = \frac{\text{Өөрийн хөрөнгө}}{ХО_{нийт}} * \Theta X_{хувь} + \frac{\text{Зээлийн хөрөнгө}}{ХО_{нийт}} * ЗХ_{хувь} * (1 - T_{хувь})$$

$\Theta X_{хувь}$	- Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувь хэмжээ;
$ЗХ_{хувь}$	- Урт хугацаат зээлийн хүүгийн хувь хэмжээ;

4.2.1. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувь хэмжээг дараах байдлаар тооцно.

Үүнд:

$$\Theta X_{хувь} = \Xi X_{хувь} + УЭЗ_{хувь} + ЗЗЭЗ_{хувь} * \beta_1$$

$\Xi X_{хувь}$	- Эрсдэлгүй хүүгийн хувь хэмжээ /Засгийн газрын бондын хүү/;
$УЭЗ_{хувь}$	- Монгол улсын эрсдлийн зэргийн хувь хэмжээ
$ЗЗЭЗ_{хувь}$	- Зах зээлийн эрсдлийн зэргийн хувь хэмжээ
$\beta_1$	- Бетта коэффициент /зээл тооцсон/
$\beta_2$	- Бетта коэффициент /өөрийн хөрөнгийн/

$$\beta_1 = \beta_2 * (1 + \frac{\text{Зээлийн хөрөнгө}}{\text{Өөрийн хөрөнгө}} * (1 - T_{хувь}))$$

Олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон Монгол улсын зээлжих зэрэглэлийг авч тооцоонд ашиглана.

4.2.2. Урт хугацаат зээлийн хүүгийн хувь хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд:

$$ЗХ_{хувь} = \Xi X_{хувь} + \text{Ахиу хүүгийн хувь}$$

### Тав. Бусад

5.1. Цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэх эрчим хүчний эх үүсвэрийн хувьд зөвхөн цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг тогтооход энэхүү аргачлалыг дараах байдлаар ашиглана. Үүнд:

5.1.1. Зөвхөн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зардлыг авч үзнэ.

5.1.2. Дулааны орлогыг жил бүрийн ашиглалтын зардлаас хасч тооцно.

5.2. Дулааны эрчим хүч дангаар үйлдвэрлэх бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн гарааны үнийг энэхүү аргачлалыг баримтлан тогтоож болно.



5.3. Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн шинэ эх үүсвэрийн эрчим хүчний үнэ тариф, гэрээний гарааны үнийг тооцож хянахад шаардлагатай дараахь материалыг хавсаргана. Үүнд:

5.3.1. Техник, эдийн засгийн үндэслэл тооцоо, жил бүрийн эрчим хүч үйлдвэрлэлт, дотоод хэрэгцээнд зарцуулах хувь хэмжээ болон нэгдсэн сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний тоо хэмжээ, эдгээрийн тооцоо судалгаа, үндэслэл тайлбар;

5.3.2. Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын дэлгэрэнгүй тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэр, төслийн барилга угсралтын хугацаа, санхүүжилтийн төлөвлөгөө, хуваарь;

5.4.3. Эрчим хүч үйлдвэрлэх үеийн ашиглалтын үйл ажиллагааны дэлгэрэнгүй зардал. Үүнд түлш, сэлбэг, материал, засвар үйлчилгээний зардал, ажиллагсдын тоо, цалин, шатахуун, харилцаа холбоо, даатгал, газрын төлбөр, татвар болон бусад зардлуудыг тооцоолж, зардал тус бүрийн нэгж үнийг тоо ширхэгээр задалж тооцсон тооцоо судалгаа, тайлбар;

5.5.4. Эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өөрийн хөрөнгийн өгөөж болон зээлийн хүүгийн тооцоолол, зээлийн үндсэн нөхцөл;

5.5.5. Эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааны санхүүгийн мөнгөн урсгалын тооцоолол, загварчлал */Төслөөс хүлээж буй санхүүгийн үр дүн болон хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн хувь, эргэх нөхөх хугацаа, зээл эргэн төлөх чадавхи, төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ зэргийг тооцож тайлбарын хамт ирүүлэх/*

-----oO-----